

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/006/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Аудитор: Д.Эрдэнэтуяа Утас: 99569599 Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТЭГСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18
.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 513
танай _____ -ны № _____ -т

Г Хязгаарлалттай дүгнэлт Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн сумын Засаг даргын 177,031.8 мянган төгрөг, Засаг даргын тамгын газрын 45,514.1 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 120,809.4 мянган төгрөг, нийт 343,355.4 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- ✓ Тайлант онд төсвийн тодотгол 1 удаа хийсэн боловч орон нутгийн хөгжлийн сан, хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлийг дутуу төлөвлөсөн,
- ✓ Үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, газрын төлбөрийн орлого, бусад орлогыг тус тус дутуу бүрдүүлсэн,
- ✓ Нийгмийн бодлогын мэргэжилтний хувийн харилцах дансанд шагнал, тэмцээн уралдааны зардал шилжүүлж, анхан шатны баримтгүй зарцуулсан, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй,
- ✓ Үндсэн үйл ажиллагааны зардлаас буудал, хоол, тэмцээн уралдааны зардал, эрсдэлийн сангаас шагнал урамшуулал, онцгой байдлын газрын барилгын зураг төсвийн үнэн, 3-р цэцэрлэгийн бохирын шугамын засварын зардалд зарцуулж эдийн засгийн ангилал зөрчсөн,
- ✓ Баялаговь ХХК-д 2023 онд урьдчилан шилжүүлсэн ажил гүйцэтгэх гэрээний авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах талаар арга хэмжээ аваагүй,

- ✓ Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд цалингийн зардлыг дутуу тусгаж орхигдуулсан,
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Энэ нь дараах хууль тогтоомж, тушаал шийдвэрийн холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" , 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;" , 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:" , 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" , 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" , 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах" , 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"
- ✓ Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-д "төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох."
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" , 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах";
- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-д "Орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх" , 32.2.3-д "Нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган энэ хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх";

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 26 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,699,461.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 5,433,669.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 796,511.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар, 469,281.0 мянган төгрөгийг зардал төлөгдөх зээлийг санхүүжүүлэхээр төлөвлөж, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,243,430.2 мянган төгрөг буюу 98 хувьтай байна.

Аудитын гол асуудал

Бор-Өндөр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 192,497.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 15,465.7 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 53,983.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 123,048.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

Орон нутгийн төсөвт 8,737,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 10,804,102.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 2,067,102.4 мянган төгрөгөөр буюу 124 хувиар давуулан биелүүлсэн байна.

Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 4,705,822.5 мянган төгрөгөөр баталж, аймгийн төсөвт 100 хувь төвлөрүүлсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж ирүүлэх үүрэгтэй боловч 54.5.4 "Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/ тайланг бэлтгэж ирүүлээгүй байна. Иймд дараагийн аудитад санхүүгийн тайлангийн бүрдлийг бүрэн хангах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТЭГСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****/мянган төгрөг/**

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		3,413,321.47	5,037,932.6
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,829,495.22	2,944,456.44
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	1,065,281.89	1,342,210.2
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	144,750	245,298.89
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	373,794.36	505,967.27
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		8,431,724.15	7,654,009.28
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	8,431,724.15	7,654,009.28
8	1.2.2.02 Биет хөрөнгө		7,796,491.15	7,017,463.78
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	635,233	636,545.5
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		11,845,045.63	12,691,942.08
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		47,523.47	244,130.92
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		47,523.47	244,130.92
13	2.1.1.03 Өглөг		47,523.47	244,130.92
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		11,797,522.15	12,447,811.17
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		11,797,522.15	12,447,811.17
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		1,375,949.91	1,375,949.91
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		2,717,148.47	3,367,437.49
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		7,704,423.77	7,704,423.77
19	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		11,845,045.63	12,691,942.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		10,945,378.55	12,853,767.73
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		7,769,596.69	10,705,105.51
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		7,174,635.18	9,944,074.7
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		7,174,635.18	9,944,074.7
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		293,299.77	388,128.69
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		301,661.75	372,902.12
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,186,956.46	2,148,662.22
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	851,143.83
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,988,825.4	0.0
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	10,478,928.73	11,654,270.49
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		10,478,928.73	11,654,270.49
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		6,773,792.46	6,896,909.2
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,364,315.92	2,752,149.51
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		276,947.21	196,701.4
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,233,145.9	1,567,251.82
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		376,390.92	356,332.6
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		43,762.54	56,432.87
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		307,166.29	193,806.85
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		42,456.4	57,955.2
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		225,311.2	256,890.7
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		1,904,296.09	1,459,388.25
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,705,136.27	4,757,361.29
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		466,449.82	1,199,497.24
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		540,850.32	549,320.23
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-540,850.32	-549,320.23
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		-74,400.5	650,177.01

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	10,534,961.39	12,693,214.24
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	7,769,596.69	10,705,105.51
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	7,174,635.18	9,944,074.7
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	293,299.77	388,128.69
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	301,661.75	372,902.12
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	128,450.51	156,270.79
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	173,211.24	166,048.89
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	50,582.44
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	750,831.1	1,988,108.74
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	750,831.1	1,144,669.95
11	1.1.1.1.04.3 Усламжин орлого	0.0	364,805.99
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	478,632.8
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,014,533.6	0.0
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,754,029.69	10,834,339.21
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	9,754,029.69	10,834,339.21
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,911,776.53	6,026,738.32
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,753,055.94	1,935,345.1
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181,787.95	149,474.45
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,180,004.46	1,472,503.41
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	150,907.61	74,977.44
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	38,764.86	1,178
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	307,631.1	262,618.07
23	1.1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал	42,574.4	27,410
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,263,899.39	1,620,607.2
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	993,150.82	482,624.65
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,842,253.16	4,807,600.89
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	780,931.71	1,858,875.04
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	775,269.19	503,913.82
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	775,269.19	503,913.82
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	775,269.19	503,913.82
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-775,269.19	-503,913.82
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	240,000
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-240,000
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	5,662.52	1,114,961.22
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,823,832.7	1,829,495.22
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,829,495.22	2,944,456.44

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,984,164.26	12,984,164.26
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,112,241.61	-1,112,241.61
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,871,922.65	11,871,922.65
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	-74,400.5	-74,400.5
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,797,522.15	11,797,522.15
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,797,522.15	11,797,522.15
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,691.56	1,691.56
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,799,213.71	11,799,213.71
9	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	-1,579.55	-1,579.55
10	1.7 Тайлант үеийн үр дүн	650,177.01	650,177.01
11	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	12,447,811.17	12,447,811.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	19,604,682.50	20,161,236.82	556,554.32	102.84
11	3.1.01.1.1 Татварын орлого	8,557,000.00	10,705,105.51	2,148,105.51	125.10
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	7,960,000.00	9,944,074.70	1,984,074.70	124.93
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	7,960,000.00	9,944,074.70	1,984,074.70	124.93
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	7,400,000.00	9,385,725.15	1,985,725.15	126.83
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	210,000.00	200,529.53	(9,470.47)	95.49
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	200,000.00	230,343.26	30,343.26	115.17
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	150,000.00	127,476.75	(22,523.25)	84.98
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	301,500.00	388,128.69	86,628.69	128.73
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	285,000.00	371,176.01	86,176.01	130.24
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	1,500.00	1,770.00	270.00	118.00
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	15,000.00	15,182.68	182.68	101.22
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	295,500.00	372,902.12	77,402.12	126.19
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	115,500.00	156,270.79	40,770.79	135.30
118001	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	32,000.00	67,818.84	35,818.84	211.93
118006	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	3,500.00	3,750.00	250.00	107.14
118009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	80,000.00	84,701.95	4,701.95	105.88
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	180,000.00	166,048.89	(13,951.11)	92.25
118101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	180,000.00	166,048.89	(13,951.11)	92.25
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	50,582.44	50,582.44	
118202	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	50,582.44	50,582.44	
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	11,047,682.50	9,456,131.32	(1,591,551.18)	85.59
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	598,357.90	524,809.42	(73,548.48)	87.71
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	140,000.00	113,966.70	(26,033.30)	81.40
120004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	238,357.90	228,337.20	(10,020.71)	95.80
120010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	180,000.00	182,009.53	2,009.53	101.12
120009	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	40,000.00	496.00	(39,504.00)	1.24
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	9,970,691.80	8,452,689.10	(1,518,002.70)	84.78
122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	9,970,691.80	8,452,689.10	(1,518,002.70)	84.78
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	478,632.80	478,632.80	-	100.00
123002	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	478,632.80	478,632.80	-	100.00
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,405,284.20	20,281,128.81	8,875,844.61	177.82

21	3.1.01.2.1	УРСГАЛ ЗАРДАЛ	10,148,214.10	19,537,214.99	9,389,000.89	192.52
210	3.1.01.2.1.1	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,366,210.10	5,072,170.59	(294,039.51)	94.52
2101	3.1.01.2.1.1.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,371,816.00	1,315,645.98	(56,170.02)	95.91
210101	3.1.01.2.1.1.1.01	Үндсэн цалин	761,902.30	769,999.41	8,097.11	101.06
210102	3.1.01.2.1.1.1.02	Нэмэгдэл	394,991.10	439,218.18	44,227.08	111.20
210103	3.1.01.2.1.1.1.03	Унаа хоолны хөнгөлөлт	150,480.00	81,018.97	(69,461.03)	53.84
210104	3.1.01.2.1.1.1.04	Урамшуулал	18,650.60	25,409.41	6,758.81	136.24
210105	3.1.01.2.1.1.1.05	Гэрээт ажлын хөлс	45,792.00	-	(45,792.00)	-
2102	3.1.01.2.1.1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	159,476.90	149,474.45	(10,002.45)	93.73
210201	3.1.01.2.1.1.2.01	Тэтгэврийн даатгал	108,444.20	105,425.63	(3,018.57)	97.22
210202	3.1.01.2.1.1.2.02	Тэтгэмжийн даатгал	12,758.20	11,769.26	(988.94)	92.25
210203	3.1.01.2.1.1.2.03	ҮОМШӨ-ний даатгал	6,379.10	6,196.04	(183.06)	97.13
210204	3.1.01.2.1.1.2.04	Ажилгүйдлийн даатгал	6,379.10	5,136.27	(1,242.83)	80.52
210205	3.1.01.2.1.1.2.05	Эрүүл мэндийн даатгал	25,516.30	20,947.25	(4,569.05)	82.09
2103	3.1.01.2.1.1.3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,588,538.30	1,472,503.41	(116,034.89)	92.70
210301	3.1.01.2.1.1.3.01	Гэрэл, цахилгаан	235,537.70	179,730.08	(55,807.62)	76.31
210302	3.1.01.2.1.1.3.02	Түлш, халаалт	1,134,690.80	1,127,955.47	(6,735.33)	99.41
210303	3.1.01.2.1.1.3.03	Цэвэр, бохир ус	218,309.80	157,017.86	(61,291.94)	71.92
210304	3.1.01.2.1.1.3.04	Байрны түрээс	-	7,800.00	7,800.00	
2104	3.1.01.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	87,593.00	73,057.46	(14,535.54)	83.41
210401	3.1.01.2.1.1.4.01	Бичиг хэрэг	14,910.70	12,811.20	(2,099.50)	85.92
210402	3.1.01.2.1.1.4.02	Тээвэр, шатахуун	52,994.40	46,839.15	(6,155.25)	88.39
210403	3.1.01.2.1.1.4.03	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,588.70	4,586.50	(1,002.20)	82.07
210405	3.1.01.2.1.1.4.05	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,563.80	-	(1,563.80)	-
210406	3.1.01.2.1.1.4.06	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,535.40	8,820.61	(3,714.79)	70.37
2105	3.1.01.2.1.1.5	Нормативт зардал	4,807.20	1,178.00	(3,629.20)	24.50
210503	3.1.01.2.1.1.5.03	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,807.20	1,178.00	(3,629.20)	24.50
2106	3.1.01.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	287,444.90	262,618.07	(24,826.83)	91.36
210601	3.1.01.2.1.1.6.01	Багаж, техник, хэрэгсэл	109,385.80	97,472.60	(11,913.20)	89.11
210603	3.1.01.2.1.1.6.03	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943.10	-	(943.10)	-
210604	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	177,116.00	165,145.47	(11,970.53)	93.24
2107	3.1.01.2.1.1.7	Томилолт, зочны зардал	30,089.00	27,410.00	(2,679.00)	91.10
210702	3.1.01.2.1.1.7.02	Дотоод албан томилолт	30,089.00	27,410.00	(2,679.00)	91.10
2108	3.1.01.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,482,213.40	1,443,874.58	(38,338.82)	97.41
210801	3.1.01.2.1.1.8.01	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,474,269.50	1,439,669.58	(34,599.92)	97.65
210802	3.1.01.2.1.1.8.02	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	961.70	-	(961.70)	-

210803	3.1.01.2.1.1.8.03	Даатгалын үйлчилгээ	1,121.30	106.92	(1,014.38)	9.54
210804	3.1.01.2.1.1.8.04	Тээврийн хэрэгслийн татвар	666.40	618.35	(48.05)	92.79
210805	3.1.01.2.1.1.8.05	Тээврийн хэрэгслийн оношлогоо	275.60	88.00	(187.60)	31.93
210806	3.1.01.2.1.1.8.06	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,955.40	2,832.00	(1,123.40)	71.60
210807	3.1.01.2.1.1.8.07	Газрын төлбөр	963.50	559.73	(403.77)	58.09
2109	3.1.01.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	354,231.40	326,408.65	(27,822.75)	92.15
210901	3.1.01.2.1.1.9.01	Бараа үйлчилгээний бусад зардал	340,790.50	315,339.55	(25,450.95)	92.53
210902	3.1.01.2.1.1.9.02	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,440.90	11,069.10	(2,371.80)	82.35
213	3.1.01.2.1.4	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,782,004.00	14,465,044.40	9,683,040.40	302.49
2131	3.1.01.2.1.4.1	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,716,822.50	14,403,203.40	9,686,380.90	305.36
213101	3.1.01.2.1.4.1.01	Засгийн газрын дотоод шилжүүлэг	4,716,822.50	4,716,822.50	-	100.00
213103	3.1.01.2.1.4.1.03	Төсвийн санхүүжилт	-	9,686,380.90	9,686,380.90	
2132	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	65,181.50	61,841.00	(3,340.50)	94.88
213205	3.1.01.2.1.4.2.04	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,300.00	21,120.00	(180.00)	99.15
213207	3.1.01.2.1.4.2.06	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,380.00	31,380.00	-	100.00
213208	3.1.01.2.1.4.2.07	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,920.00	7,920.00	-	100.00
213209	3.1.01.2.1.4.2.08	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,581.50	1,421.00	(3,160.50)	31.02
22	3.1.01.2.2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	796,511.40	503,913.82	(292,597.58)	63.27
223001	3.1.01.2.2.4	Бусад хөрөнгө	796,511.40	503,913.82	(292,597.58)	63.27
23	3.1.01.2.3	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	460,558.70	240,000.00	(220,558.70)	52.11
230001	3.1.01.2.3.1	Эргэж төлөгдөх зээл	460,558.70	240,000.00	(220,558.70)	52.11
8	3.1.01	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	8,199,398.30	(119,891.99)	(8,319,290.29)	(1.46)
9	3.1	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(8,199,398.30)	119,891.99	8,319,290.29	(1.46)
7	3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(8,199,398.30)	119,891.99	8,319,290.29	(1.46)
4	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,829,459.40	1,829,459.40	
5	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,943,259.21	2,943,259.21	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	364,805.99
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	364,805.99
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	364,805.99
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	364,805.99
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	364,805.99
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,649.09
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	351,156.90
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	335,868.60
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	335,868.60
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	335,868.60
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	1,919.98
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	1,919.98
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	176,732.62
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	176,732.62
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	157,216.00
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	157,216.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	28,937.39
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(28,937.39)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(28,937.39)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Бор-Өндөр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 3 байгууллага, 1 төрийн сан, 2 тусгай сан, 1 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, улсын төсвийн 9 байгууллагын тогтмол зардал, нийт 16 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад санал дүгнэлт гаргаж, 11 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын тамгын газарт аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт, ерөнхий боловсролын Бор-өндөр сургуульд Ари файнэнс аудит ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт, суман дахь Мэргэжлийн боловсролын сургууль, сумын нэгдсэн эмнэлэгт Платиниум прогресс аудит ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт тус тус гаргасан байна.

5.1 Тус сумын харьяа орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар:

Орон нутгийн төсвийн харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 564,929.7 мянган төгрөгийн 18 алдаа, зөрчил илэрснээс 221,574.3 мянган төгрөгийн 22 алдааг аудитын явцад залруулж, 3,369.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 216,937.5 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 5 албан шаардлага, 123,048.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт: Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Засаг даргын тамгын газар:

- ✓ Соёлын төвийн засварын зураг төсвийн урьдчилгаа 8,000.0 мянган төгрөгийн шилжүүлсэн боловч урьдчилж гарсан зардалд бүртгээгүй зардалд хаасан.
Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгө, Засаг даргын мөрийн хөтөлбөр, Эрсдэлийн сангаас худалдан авсан бусад байгууллагад хүлээлгэн өгөх 93,048.8 мянган төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, хүлээн авсан акт байхгүй, хүлээлгэж өгөөгүй.
Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан
- ✓ Тайлант хугацаанд худалдан авсан 38,129.8 мянган төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгалгүй орхигдуулсан байна.
Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан
- ✓ Зос хаан норов ХХК-аас нэхэмжилсэн 377.0 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал, Баянзаг динозавр ХХК-аас худалдан авсан онцгой байдлын тоног төхөөрөмжийн үлдэгдэл төлбөр болох 18,350.0 мянган төгрөг, Эко лэнд менежмент ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний үлдэгдэл төлбөр 3,600.0 мянган төгрөг нийт 22,327.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй орхигдуулсан байна.
Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан

- ✓ Нийгмийн бодлогын мэргэжилтэний хувийн харилцах дансанд 3,369.2 мянган төгрөгийг шагнал, тэмцээн уралдааны зардалд шилжүүлж, анхан шатны баримтгүй зарцуулж, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

- ✓ Үндсэн үйл ажиллагааны зардлаас 9,794.4 мянган төгрөгийг буудал, хоол, тэмцээн уралдааны зардалд, эрсдэлийн сангаас 10,000.0 мянган төгрөгийг шагнал урамшуулалд, 6,500.0 мянган төгрөгийг онцгой байдлын газрын барилгын зураг төсвийн үнэнд, 2,403.0 мянган төгрөгийг 3-р цэцэрлэгийн бохирын шугам засварт, нийт 28,697.4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

- ✓ Усан сан байгуулах, усны нөөцийн сав авах ажил гүйцэтгэх гэрээний дагуу Баялагговь ХХК-д 2023 онд урьдчилан шилжүүлсэн 9,000.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

- ✓ Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 4,447.4 мянган төгрөгийн цалинг тайлагнаагүй дутуу тусгаж орхигдуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

- ✓ Бор-өндөр сумын Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч нь нийт 230,815.8 мянган төгрөгийг өөрийн хувийн харилцах болон 1 иргэн, 1 аж ахуй нэгж байгууллагын харилцах дансанд дэнчин, нийгмийн даатгалын шимтгэл гэсэн гүйлгээний утгатайгаар шилжүүлсэн нь гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал үүссэн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн

Иргэдийн төлөөлөгчдийн хурал:

- ✓ Бараа материалын сэлбэг хэрэгсэл дансанд шинээр худалдан авсан видео камер 3,300.0 мянган төгрөг, микрофон, микрофоны утас 1,408.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг дансны ангилал буруу бүртгэж тайлагнасан.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан

Орон нутгийн хөгжлийн сан:

- ✓ Санхүүгийн тайланд 9,950.0 мянган төгрөгийн зарлагыг тусгалагүй орхигдуулсан.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан

- ✓ Малын тоо толгойн албан татварын орлогын 21,665.6 мянган төгрөгийг санхүүгийн тайланд буруу илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан

- ✓ Санхүүгийн тайланд тусгагдсан авлагын үлдэгдэл 78,646.9 мянган төгрөг, өглөгийн үлдэгдэл 42,162.5 мянган төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

Хоршоо хөгжүүлэх сан:

- ✓ Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн үр дүнгийн тайланд 1,365.8 мянган төгрөгийн орлогыг буруу илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан

- ✓ Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд зээл, зээлийн хүүгийн авлагыг 5,005.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан

Цэгцүүлэн дом өрхийн эрүүл мэндийн төв

- ✓ Бараа материалын дэлгэрэнгүй тайлангийн эм боох материал, бичиг хэрэг, аж ахуйн материалын дансны эхний үлдэгдэл тодруулгын тайлангийн эхний үлдэгдлээс 1,908.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан..

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан

Улсын төсвийн харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 87,532.2 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс 72,494.0 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 2,915.4 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 12,122.7 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 4 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитын илрүүлэлт: Улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Эрүүл мэндийн төв:

- ✓ Тайлант онд 1 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүй 560.4 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

Нэгдүгээр цэцэрлэг:

- ✓ Тайлант онд 2 албан хаагчид 312.2 мянган төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулан, мөн 1 албан хаагчид 736.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүй тус тус олгосон.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

Бор-Өндөр сүман дахь Мэргэжлийн боловсролын сургууль:

- ✓ Тайлант онд илүү цагийн хөлсийг дараах албан хаагчид илүү олгосон байна. Үүнд: Захирал 8 цаг 128.8 мянган төгрөг, нягтлан бодогч 39 цаг 561.6 мянган төгрөг, нярав 24 цаг 229.5 мянган төгрөг, нийт 920.1 мянган төгрөгийг хэтрүүлэн олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

Ерөнхий боловсролын Бор-Өндөр сургууль

- ✓ Тайлант онд худалдаж авсан 41,669.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа үйлчилгээний зардлаар бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан

- ✓ Түрээсийн орлогыг хүн нэг бүрээр тооцоо үүсгэж бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан

- ✓ Газар эзэмших эрхийн /000002285, 000002304, 000002288/ дугаар бүхий гэрчилгээтэй 11559 кв.м талбайтай 3 газрын талбайн хэмжээ, кв.м -ын нэг бүрийн үнэ тавилгүйгээр бөөн дүнгээр нягтлан бодох бүртгэлд тусгаасан байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан

- ✓ Шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аль түвшинд ямар амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 2 ажилтанд 20 хувь, 1 ажилтанд 5 хувиар илүү тооцож олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

- ✓ Ажлын байр түрээслэсэн 2 иргэнтэй байгуулсан гэрээг аудитад ирүүлээгүй, орлогыг мөнгөн сууриар бүртгэсэн, түрээслэгч нэг бүр дээр тооцоо үүсгэж бүртгээгүй, гэрээ дүгнэсэн акт үйлдэж эцсийн тооцоо хийгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

- ✓ Ур чадварын нэмэгдлийг хагас жил тутам холбогдох шалгуур үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнэдэггүй зөвхөн тухайн үеийн гаргасан амжилтыг үнэлж нэмэгдэл олгодог, журмын дагуу олгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

- ✓ Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

- ✓ Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 11 нэр төрлийн 9,032.7 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн

Бор-Өндөр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл:

Аудитаар 15,465.7 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залрууллаа.

- ✓ 2025 оны 12 дугаар сарын 30.31-ны өдрүүдэд арилжааны банкнаас шилжүүлсэн албан татвар, төлбөр, хураамжийн замд яваа мөнгөн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсан алдааг залруулсан.

Аудитаар нийт 177,0318 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 53,983.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 123,048.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй

5.2 Албан шаардлага

- ✓ Сумын Засаг дарга нь орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс 42,868.3 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдлээс 11,114.8 мянган төгрөгийг тус тус бүрэн төлөвлөөгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх," 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх," 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх

төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;" гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Албан шаардлагын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэх

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Үйл ажиллагааны орлогыг 9,470.4 мянган төгрөг, хөрөнгө борлуулсны орлогыг 22,523.2 мянган төгрөг, газрын төлбөрийн орлогыг 26,033.3 мянган төгрөг, бусад орлогыг 39,504.0 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 11,386.6 мянган төгрөгөөр тус тус дутуу бүрдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1: 41.2. Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх; гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор батлагдсан орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлж ажиллах.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ." гэсэн заалтын дагуу төлөвлөгөөг 1 сарын дотор, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгалгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Засаг дарга	1	15,465.72	1	15,465.72			1	15,465.72				
ЗДТГ	4	161,505.77	4	161,505.77			4	161,505.77				
ИТХ	1	4,708.00			1	4,708.00	1	4,708.00				
ӨЭМТөө	1	1,908.06			1	1,908.06	1	1,908.06				
ХХСан	2	6,371.08			2	6,371.08	2	6,371.08				
ОНХСан	2	31,615.68	1	9,950.00	1	21,665.68	2	31,615.68				
ОН-ийн байгууллагын дүн	11	221,674.31	6	186,921.49	5	34,652.82	11	221,674.31	0	0.00	0	0.00
ЕБСургууль	3	72,494.00			3	72,494.00	3	72,494.00				
УТ-ийн байгууллагын дүн	3	72,494.00	0	-	3	72,494.00	3	72,494.00	0	-	0	-
Дүн	14	294,068.31	6	186,921.49	8	107,146.82	14	294,068.31	0	-	0	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	2	177,031.83			1	53,983.20	1	123,048.63
ЗДТГ	4	45,514.14	1	3,369.27	3	42,144.87		
ОНХСан	1	120,809.47			1	120,809.47	0	-
ОН-ийн байгууллагын дүн	7	343,355.44	1	3,369.27	5	216,937.54	1	123,048.63
МБСургууль	1	920.12	1	920.12				
1-р цэцэрлэг	1	1,048.87	1	1,048.87				
Бор-өндөр сургууль	5	10,061.07	1	386.00	3	9,675.07	1	-
Нэгдсэн эмнэлэг	1	560.44	1	560.44				
УТ-ийн байгууллагын дүн	8	12,590.50	4	2,915.43	3	9,675.07	1	-
Дүн	15	355,945.94	5	6,284.70	8	226,612.61	2	123,048.63

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	-	0	-	0	-	0	-
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	0	-	0	-	0	-	0	-
ОН-ийн байгууллагын дүн	0	-	0	-	0	-	0	-
МБСургууль					1	2,447.70		
УТ-ийн байгууллагын дүн	1	2,447.70	0	-	1	2,447.70	0	-
Нийт дүн	1	2,447.70	0	-	1	2,447.70	0	-



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 272-А/2371125

Чингис хот

ХЭА-2026/006/НА-СТА-ТТЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг дарга нь орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 42,868,394.40 (дөчин хоёр сая найман зуун жаран найман мянга гурван зуун ерэн дөрөв) төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдлээс 11,114,806.18 (арван нэгэн сая нэг зуун арван дөрвөн мянга найман зуун зургаан) төгрөгийг тус тус бүрэн төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх," 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх," 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах," гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Д.Отгонцэцэг-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ж.ГАНБААТАР
Д.ЭРДЭНЭТУЯА